30	Хувилагч машин Canon IR2018	NPG-28	8300	Албан ёсны оригиналь/genuine/ хор үйлдвэрлэдэг үйлдвэрт үйлдвэрлэсэн Certificate байх	15
31	Принтер лазер Canon LBP 3050		1800	Албан ёсны оригиналь/genuine/ хор үйлдвэрлэдэг үйлдвэрт үйлдвэрлэсэн Certificate байх	8

Дараах принтерийн хорнуудын үнийн саналыг ирүүлнэ. Ирүүлсэн үнийн санал нь  
принтерийн хорны тендерийн үнэлгээнд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй болно. Тус үнийн  
саналыг шаардлагатай үед гэрээний нэмэлтээр ашиглахад оршино.

1	Принтер Canon IX6560			1
2	Принтер Epson PLQ 20 /НДЛ-т хэвлэгч /	Epson PLQ 20	Standard capacity developer cartridge (1,800 pages)	1
3	Принтер HP-MFP-OJ 7612			1
4	Хувилагч машин SHARP AR-5623N			1

Захиалагчийн бараа материал захиалан авах дээд хэмжээг заасан бөгөөд тухайн бараа материалыг захиалан авах тоо ширхэг нь компанийн хэрэгцээ шаардлагад үндэслэн багасч болно. Захиалагч бараа, материалыг хүснэгтэд заасан дээд хэмжээгээр хүлээн авах үүрэг хүлээхгүй.

## 1. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө].

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермиин нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8
<b>Принтерийн хор нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулаж ЭТТ/201901 289 дугаар бүхий нээлттэй тендер</b>	Захиалагч захиалга гаргаж тодорхой тоогоор авах ба тухай бүрд нийлүүлэгч 7-гоос 14 хоногийн дотор нийлүүлнэ.	1	Дэдээ	“Эрдэнэс-Таван толгой” ХК, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8, Финанс төв, Улаанбаатар хот-15160, Монгол улс	Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 5 хоног	Гэрээний хугацаа дуустал заасан тоо хэмжээнээс хэтрэхгүй нийлүүлэх, гүйцэтгэлээр тооцоо хийх	[Гэрээ хучин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]

## **2. Холбогдох үйчилгээний жагсаалт ба гүйцэтгэлийн хуваарь**

*[Энэхүү хүснэгтийг захиалагч бөглөнө. Үйлчилгээг гүйцэтгэх дуусах хугацааг аль болох бодитой байхаар тооцон, бараа нийлүүлэх хугацаатай уялдуулан тогтооно].*

1	2	3	4	5	6
Нэр төрөл	Үйлчилгээний талаархи тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Үйлчилгээг гүйцэтгэх газар болон ажлын талбай	Үйлчилгээг гүйцэтгэж дуусгах огноо

### **3. Техникийн тодорхойлолт бэлтгэх санамж**

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай байгаа бараа болон холбогдох үйлчилгээний техникийн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлоход оршдог.

Ойлгомжтой бөгөөд сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно. Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ өрсөлдөөнийг аль болох өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд үүний зэрэгцээ худалдан авах бараа, үйлчилгээний шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд л худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийг үнэлэх үнэлгээ зөв явагдана.

Гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, орчин үеийн загварын, мөн зураг төсөл, материалын хувьд сүүлийн үеийн хандлагыг хангасан байх нөхцөлийг техникийн тодорхойлолтод шаардвал зохино.

Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай. Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ метрийн системийг ашиглана. Бүх салбарт хэрэглэж болох нийтлэг жишиг техникийн тодорхойлолт гэж байхгүй. Бүх төрлийн барааны стандарт буюу ерөнхий техникийн тодорхойлолт боловсруулж стандартчилах нь чухал ач холбогдолтой. Энэ стандарт техникийн тодорхойлолтыг тухайн бараанд нийцүүлэн, зохих өөрчлөлт оруулах замаар ашиглана.

Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Бараа, материалын, техникийн тодорхойлолтодаль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа, материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

#### **Жишиг заалт: Стандарт болон кодын дүйцэх байдал**

Гэрээнд өөрөөр заагаагүй бол техникийн тодорхойлолтод дурдсан нийлүүлэгдэх бараа, материал, тэдгээрийг турших стандарт, кодыг уг стандарт буюу кодын тухайн үед мөрдөгдөж буй хувилбарт тодорхойлсноор хэрэглэнэ. Үндэсний стандарт, кодыг заасан тохиолдолд түүнтэй дүйцэх, эсхүл түүнээс илүү чанартай олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бусад стандарт, кодыг хүлээн зөвшөөрнө.

Барааны тэмдэг, каталогийн дугаарыг заасан шаардлагыг аль болох тавихгүй байна. Зайлшгүй шаардлагын улмаас эдгээрийг хэрэглэх бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэж нэмж заана.

Шаардлагатай тохиолдолд захиалагч зураг болон ажлын талбайн төлөвлөгөөг тендерийн баримт бичгийн хамт тендерт оролцогчдод өгнө. Үндэсний стандарт, кодыг заасан тохиолдолд түүнтэй дүйцэх, эсхүл түүнээс илүү чанартай олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бусад стандарт, кодыг хүлээн зөвшөөрнө.

Хэрвээ захиалагч техникийн тодорхойлолтын хураангуйг гаргуулахаар бол дараах хүснэгтийг ашиглан шаардлагатай мэдээллийг тусгаж өгнө. Тендерт оролцогч санал болгож буй бараа, үйлчилгээ нь уг шаардлагад нийцэж байгаа эсэхийг ижил хүснэгтээр харуулна.

**Бараа нийлүүлэх тендерийн жишиг баримт бичиг**

**Техникийн тодорхойлолтын хураангуй.** Нийлүүлэгдэх бараа болон холбогдох үйлчилгээ нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

<i>Нэр төрлийн дугаар</i>	<i>Бараа болон холбогдох үйлчилгээний нэр</i>	<i>Техникийн тодорхойлолт болон стандарт</i>

## 4. Зураг, төсөл

Тендерийн баримт бичигт зураг, төсөл ирүүлэх шаардлагатай бол дараах хүснэгтийг ашиглана.

Зураг төслийн жагсаалт		
Зураг, төслийн дугаар.	Зураг төслийн нэр	Зориулалт

## 5. Шалгалт, туршилт

Захиалагч шаардлагатай бол нийлүүлэгдэх барааны хувьд хийгдсэн байх ёстой үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилтын жагсаалтыг холбогдох мэдээллийн хамт ирүүлэхийг тендерт оролцогчоос шаардаж болно.

## ГУРАВДУГААР ХЭСЭГ

### ЗУРГААДУГААР БҮЛЭГ

#### ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

##### Гэрээний ерөнхий нөхцөлийн санамж

Гэрээний ерөнхий нөхцөл болон гэрээний тусгай нөхцөл, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх үүргийг тодорхойлох баримт бичиг болно.

Гэрээний ерөнхий нөхцөлд өөрчлөлт оруулах шаардлагатай бол үүнийг гэрээний тусгай нөхцөлд тусгана.

**ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

**ГАРЧИГ**

1. Нэр томъёо
2. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах
3. Захиалгыг өөрчлөх
4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах
5. Туслан гүйцэтгэх гэрээ байгуулах
6. Барааны гарал үүслийн улс
7. Шалгалт, туршилт
8. Баглаа боодол
9. Барааны нийлүүлэлт болон баримт бичгийн бүрдүүлэлт
10. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх
11. Гүйцэтгэлийн баталгаа
12. Даатгал
13. Чанарын баталгаа, баталгаат засвар
14. Төлбөр
15. Үнэ
16. Хуваарийг сунгах
17. Алданги оногдуулах
18. Үргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах
19. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах
20. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах
21. Маргааныг шийдвэрлэх
22. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал
23. Гэрээний үүргийг шилжүүлэх
24. Гэрээнд ашиглах хэл
25. Татвар, хураамж
26. Гарчиг
27. Үүргийн гүйцэтгэл

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1. Нэр томъёо** 1.1. Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
- (а) “гэрээ”гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд байгуулсан бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.
  - (б) “гэрээний үнэ” гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн болон зохих хэмжээнд гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.
  - (в) “бараа” гэж нийлүүлэгчээс захиалагчид гэрээний дагуу нийлүүлэх тоног төхөөрөмж, машин механизм болон бусад материалыг хэлнэ.
  - (г) “бусадүйлчилгээ” гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ, угсралт, техникийн туслалцаа, сургалт зэрэг гэрээний дагуу нийлүүлэгчийн үзүүлэх аливаа дагалдах ажил, үйлчилгээ, үүргийг хэлнэ.
  - (д) “захиалагч” гэж барааг худалдан авч буй гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.
  - (е) “нийлүүлэгч” гэж гэрээнд заасан бараа, үйлчилгээг нийлүүлж буйтэйгээдийг хэлнэ.
  - (ж) “ажлын талбай” гэж гэрээний тусгай нөхцөлд тодорхойлсон газрыг хэлнэ.
  - (з) “хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
- 2. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах** 2.1. Нийлүүлэгч нь захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд гэрээ ба түүний нөхцөл, эдгээртэй холбогдуулж захиалагчийн өгсөн техникийн тодорхойлолт, зураг, загвар, дээж зэрэг мэдээллийг гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтнаас бусад этгээдэд задлаж болохгүй. Гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг зөвхөн түүний хариуцсан ажилд шаардлагатай мэдээллээр хангана.
- 2.2. Захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд, нийлүүлэгч 2.1-т дурдсан баримт бичиг болон мэдээллийг гэрээ гүйцэтгэхээс бусад зорилгоор ашиглахгүй.
- 2.3. 2.1-т дурдсан гэрээнээс бусад баримт бичиг захиалагчийн өмч хэвээр үлдэх ба хэрэв захиалагч хүсвэл нийлүүлэгч гэрээний үүргээ гүйцэтгэж дуусмагц (бүх хувийг) захиалагчид буцааж өгнө.
- 2.4. Захиалагчийнлуулэгчийн гэрээний гүйцэтгэлд хамаарах данс, бүртгэлийг шалгах эрхтэй ба аудитор томилж эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийлгэх эрхтэй.
- 3. Захиалгыг өөрчлөх** 3.1. Захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээний ерөнхий цар хүрээнд багтаан дор дурдсан нэг буюу түүнээс дээш зүйлийн захиалгыг хэдийд ч өөрчлөх эрхтэй. Үүнд:

- (a) гэрээний дагуу нийлүүлэгдэх барааг захиалагчид зориулан тусгайлан үйлдвэрлэсэн байхаар зураг, зураг төсөл, техникийн тодорхойлолтыг өөрчлөх;
  - (б) тээвэрлэлтийн болон баглаа боодлын хэлбэр;
  - (в) барааг хүргэх газар.
- 3.2. Нийлүүлэгч нь захиалгын өөрчлөлтийн (цаашид “өөрчлөлт” гэх) улмаас гэрээнд заасан бараа нийлүүлэх хугацаанд үзүүлэх нөлөөг (хэрэв нөлөөлөх бол) харгалzan түүний зардлын нарийчилсан тооцоо, хэрэгжүүлэх хуваарийг гаргаж, өөрчлөлтийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор захиалагчид танилцуулна.
- 3.3. Захиалагч 3.2-т дурдсан нийлүүлэгчийн тооцоог үндэслэж өөрчлөлтийг бичгээр батлах ба ийнхүү баталгаажуулах хүртэл нийлүүлэгч 3.1-д дурдсан өөрчлөлтийг гүйцэтгэхгүй.
- 3.4. Харилцан тохиролцсон өөрчлөлт нь гэрээний хэсэг болох ба энэ өөрчлөлтөд гэрээний нөхцөл, болзول үлчилнэ.
- 4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах**
- 4.1. Энэхүү гэрээний 3 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд гэрээний нөхцөл, болзлыг засварлах, эсхүл өөрчилж болохгүй. Зайлшгүй шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурна.
- 5. Туслан гүйцэтгэх гэрээ байгуулах**
- 5.1. Захиалагч урьдчилж бичгээр зөвшөөрөөгүй тохиолдол нийлүүлэгч гэрээ болон түүний аль нэг хэсгийг туслан гүйцэтгүүлэх зорилгоор туслан гүйцэтгэгч сонгож түүнтэй гэрээ байгуулж болохгүй.
- 5.2. Нийлүүлэгч гэрээг хэрэгжүүлэхдээ сонгосон аливаа туслан гүйцэтгэгч нь өөрийн хариуцсан ажил үүрэгт ногдох гэрээний холбогдох нөхцөл, болзлыг бүрэн биелүүлэхийг батламжилна.
- 6. Барааны гарал үүслийн улс**
- 6.1. Гэрээний дагуу нийлүүлэх бараа нь аль ч улсаас гарал үүсэлтэй байж болно.
- 6.2. Барааны гарал үүслийн улс гэдэгт барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн газрыг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.
- 7. Шалгалт болон туршилт**
- 7.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Гэрээний тусгай нөхцөлд эсвэл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. Захиалагч шалгалт, туршилт хийхээр томилсон төлөөлөгч(д)ийг нийлүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.
- 7.2. Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар, барааг хүргэх газар болон эцсийн цэгт явуулж болно. Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар явуулсан тохиолдолд захиалагчийг шаардлагатай байгууламж, зураг, үйлдвэрлэлийн өгөгдөл болон бусад туслалцаагаар үнэ төлбөргүй хангана.

- |   |  |
|---|--|
|   | <p>7.3. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна.</p> <p>7.4. Барааг тээвэрлэхээс өмнө захиалагч, эсхүл түүний төлөөлөгч шалгасан, туршсан байх нь Монгол Улсад орж ирсний дараа түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд татгалзаж болох захиалагчийн эрхийг хөндөхгүй.</p> <p>7.5. Энэ зүйлийн аль ч нөхцөл, болзол нийлүүлэгчийг гэрээний баталгаат засварын болон бусад үүргээс чөлөөлөхгүй.</p>  |
| <b>8. Баглаа боодол</b>                                   | <p>8.1. Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх баглаа боодлоор гэрээнд заасны дагуу хангана. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон давс, хур тундас зэргийг хангалттай тээвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгоходо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрт ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлийг харгалзсан байна.</p> <p>8.2. Баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичигийг бэлтгэхдээ гэрээнд, нэн ялангуяа гэрээний тусгай нөхцөлд заасан шаардлага болон захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг чанд мөрднө.</p> |
| <b>9. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b> | <p>9.1. Нийлүүлэгч техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу барааг нийлүүлнэ. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлийн найруулга, хувилбарыг хэрэглэнэ. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан бол түүний дагуу тээврийн болон бусад бичиг баримтыг бэлтгэж бүрдүүлнэ.</p> <p>9.2. Гэрээнд хэрэглэсэн CIP /СИП/, EXW /ИКСБ/, FOB /ФОБ/, FCA/ФСА/, CIF /СИФ/ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.</p>  |
| <b>10. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх</b>              | <p>10.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглах явцад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн тохиолдолд гомдлыг нийлүүлэгч барагдуулж холбогдон гарах зардлыг хариуцна.</p>   |
| <b>11. Гүйцэтгэлийн баталгаа</b>                          | <p>11.1. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан мөнгөн дүн бүхий гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор захиалагчид өгнө.</p> <p>11.2. Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэж чадаагүйгээс захиалагчид учрах хохирлыг нөхөж барагдуулахад уг баталгаа зориулагдана. Гэрээний гүйцэтгэлийг ГЕН-ийн 16.2-ын дагуу сунгахад нийлүүлэгч мөн хугацаагаар гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй хугацааг сунгана.</p>   |

- 11.3. Гүйцэтгэлийн баталгаа нь ТОӨЗ-ны 16 дугаар зүйлд заасан валютаар гаргасан банкны баталгаа, Засгийн газрын бонд эсхүл Засгийн газрын хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр гаргасан баталгаа байна.
- 11.4. Нийлүүлэгч гэрээний дагуу гүйцэтгэх ажлыг дуусгавар болгосноос хойш 30 хоногийн дотор захиалагч гүйцэтгэлийн баталгааг хүчингүй болгоно.
- 12. Даатгал**
- 12.1. ГТН-д тусгайлан өөрөөр заагаагүй бол барааг үйлдвэрлэх, худалдаж авах, тээвэрлэх, нийлүүлэх, хадгалах, болон хүргэх үед гарч болох алдагдал, гэмтэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалж бүх барааг ГТН-д заасан хэлбэрээр инкотермсийн нөхцөлийн дагуу даатгуулна.
- 13. Чанарын баталгаа, баталгаат засвар**
- 13.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь шинэ, урьд өмнө ашиглагдаагүй, гэмтэл согогтүй бөгөөд хамгийн сүүлийн буюу өнөөгийн загварын, техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн орчин үеийн шинэлэг ололтуудыг агуулсан байна. Өөрийн болон туслан гүйцэтгэгчийн бараа нийлүүлэхэд ашиглах бүх материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл зэрэг нь шинэ, сайн чанарын болон зориулалтынх байна гэдгийг нийлүүлэгч баталгаажуулна.
- 13.2. ГТН-д өөрөөр заагаагүй бол баталгаат засвар нь барааг хүргэж, ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 12 сар, эсхүл барааны гарал үүслийн улсын боомтоос ачсан өдрөөс хойш 18 сар гэсэн хугацааны аль эрт дуусах хугацаанд хүчинтэй байна.
- 13.3. Захиалагч энэхүү баталгаатай холбогдох гомдлыг нийлүүлэгчид бичгээр шуурхай мэдэгдэнэ.
- 13.4. Нийлүүлэгч энэхүү мэдэгдлийг хүлээн аваад гэмтэл согогтой бараа, эсхүл түүний эд ангийг үнэ төлбөргүй, шуурхай засварлах буюу солино.
- 13.5. Захиалагч нь 13.2 заасныг үл харгалзан, 13.4-т заасны дагуу гэмтэл согогийг арилгаснаас хойш 12 сарын дотор засварласан бараанд энэ төрлийн гэмтэл согог дахин гарсан тухай бичгээр мэдэгдэл ирвэл уг гэмтэл согогийг үнэ төлбөргүй шуурхай арилгана.
- 13.6. Хэрэв нийлүүлэгч гэмтэл согог гарсан мэдэгдэл хүлээн аваад гэрээний дагуу түүнийг арилгахгүй бол захиалагч өөрөө нийлүүлэгчийн зардлаар уг гэмтэл согогийг арилгах эрхтэй. Энэ зүйлд заасны дагуу нийлүүлэгчийн гаргах баталгаа нь гэрээнд заасан захиалагчийн бусад эрх, үйл ажиллагааг хязгаарлахгүй.
- 14. Төлбөр**
- 14.1. Гэрээний дагуу нийлүүлэгчид төлөх төлбөрийн хэлбэр, нөхцөлийг ГТН-д дурдана.
- 14.2. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ бүрэн биелүүлсний дараагаар төлбөр хийхийг хүссэн хүсэлтийг төлбөрийн нэхэмжлэх болон ГЕН-ийн 9 дүгээр зүйлд заасан баримт бичгийн хамт захиалагчид хүргүүлнэ.
- 14.3. ГТН-д өөрөөр заагаагүй бол захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээнавснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ.
- 14.4. Гэрээний дагуу нийлүүлэгчид хийх төлбөрийг тендерийн маягтад дурдсан валютаар хийнэ.

<b>15. Үнэ</b>	15.1. Гэрээний дагуу хүргэсэн бараа болон гүйцэтгэсэн үйлчилгээний үнийг нэхэмжлэхдээ нийлүүлэгч өөрийн тендерт санал болгосон үнийг баримтлана. ГТН-ийн үнэ тохируулах нөхцөлийн дагуу үнийг тохируулах, эсхүл ГЕН-ийн З дугаар зүйлийн дагуу захиалгыг өөрчлөхөд тендерт санал болгосон үнэ өөрчлөгдвэл, өөрчлөгдсөн үнийг баримтлана.
<b>16. Хуваарийг сунгах</b>	<p>16.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.</p> <p>16.2. Нийлүүлэгч дараах тохиолдолд бараа нийлүүлэлтийн хуваарийг сунгах тухай хүсэлт гаргаж болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>(а) захиалагч ГЕН-ийн З дугаар зүйлд заасны дагуу захиалгыг өөрчилсөн;</li> <li>(б) захиалагчаас гаргаж өгөх материал, зураг, эсхүл үйлчилгээ хугацаа хоцорсон (үйлчилгээ гэдэгт гэрээний дагуу захиалагчийн гаргах зөвшөөрөл, баталгаа орно);</li> <li>(в) ГЕН-ийн 22 дугаар зүйлд заасан гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдал үүсвэл;</li> <li>(г) захиалагчийн өгсөн захиалгаас шалтгаалан ажлын гүйцэтгэл хойшилсон.</li> </ul> <p>Нийлүүлэгч хугацаа хоцрооос урьдчилан сэргийлэхийн тулд бололцоотой бүхнийг хийсэн гэдгийг захиалагчид нотлон харуулах үүрэгтэй. Хугацаа хоцролтын шалтгааныг арилгах, даван туулах арга замуудыг талууд хэлэлцэнэ.</p> <p>16.3. Гүйцэтгэгч 16.2-т заасан нөхцөл байдал бий болсны улмаас бараа нийлүүлэлтийн хуваарь ямар нэг байдлаар хоцорч болох тухай захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдээгүй, эдгээр нөхцөл байдал бий болсныг нотлон харуулаагүй тохиолдолд 16.2-ыг үл харгалзах ба хуваарийг сунгахгүй.</p>
<b>17. Алданги оногдуулах</b>	17.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг уг хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэх ёсгүй. Дээд хэмжээнд хүрсэн тохиолдолд захиалагч ГЕН-ийн 18 дугаар зүйлийн дагуу цуцлах тухай асуудлыг хөндөж болно.
<b>18. Үргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах</b>	<p>18.1. Захиалагч дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд гэрээний дагуу зөрчлийг арилгах бусад арга хэрэгслийг ашиглалгүйгээр нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>(а) нийлүүлэгч аль нэг болон бүх барааг гэрээнд заасан эсвэл ГЕН-ийн 16 дугаар зүйлийн дагуу сунгасан хугацаанд хүргэж чадаагүй;</li> <li>(б) нийлүүлэгчийн ирүүлсэн бараа нь техникийн тодорхойлолтын шаарлага хангагүй бөгөөд гэрээний бусад үүргээ биелүүлээгүй;</li> <li>(в) нийлүүлэгч 18.1.(а), 18.1.(б)-д заасан нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг захиалагчаас хүлээн аваад 10 хоногийн дотор (захиалагч үүнээс урт хугацаа заах эрхтэй) алдаагаа залруулаагүй;</li> </ul>

		(г) нийлүүлэгч тендер шалгаруулалтад оролцох, гэрээ байгуулах, хэрэгжүүлэхдээ авлигал, залилан мэхлэх зохиомол тохиролцоо хийх болон айлган сүрдүүлэх үйлдэлд холбогдоныг шүүх, эсхүл эрх бүхий байгууллага тогтоосон бол захиалагч түүнд гэрээ байгуулах эрх олгохгүй бөгөөд нэгэнт гэрээ байгуулах эрх олгогдсон, эсхүл гэрээ байгуулагдсан бол түүнийг цуцална.
	18.2.	18.1-ийн дагуу гэрээг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн цуцалсан тохиолдолд захиалагч нийлүүлэгдээгүй барааг тохиромжтой гэж үзсэн нөхцөлөөр захиалагч худалдан авах эрхтэй ба үүнтэй холбогдон гарсан нэмэлт зардлыг нийлүүлэгч хариуцна. Энэ зүйлийг үл харгалзан нийлүүлэгч гэрээний цуцлагдаагүй хэсгийг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.
19. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах	19.1.	Нийлүүлэгч дампуурах, эсхүл бусад хэлбэрээр төлбөрийн чадваргүй болсон бол захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй. Ингэхдээ захиалагч нийлүүлэгчид учирсан хохирлыг нөхөн төлөхгүй. Гэвч ийнхүү цуцалсан нь захиалагчид үүссэн эсвэл ирээдүйд үүсэх аливаа эрхийг, хөндөхгүй.
20. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах	20.1.	Захиалагч шаардлагатай тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдэж гэрээг хэдийд ч бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. <sup>7</sup> Захиалагч мэдэгдэлдээ өөрийн шаардлагаар гэрээг цуцлах болсон үндэслэл болон гэрээний аль хэсгийг, хэзээнээс цуцалж буйг заавал дурдана.
	20.2.	Мэдэгдэл нийлүүлэгчид очсоноос хойш 30 хоногийн дотор тээвэрлэхэд бэлэн болсон барааг захиалагч гэрээнд заасан үнэ болон бусад нөхцөлөөр худалдаж авна. Үлдэх барааны хувьд захиалагч дор дурдсан сонголтын аль нэгийг, эсхүл хоёуланг хэрэгжүүлнэ. Үүнд:
		(а) үлдэх барааны одоогоор бэлэн болсон аливаа хэсгийг гэрээнд заасан үнэ, бусад нөхцөлөөр авах, болон/эсхүл
		(б) үлдэх барааг цуцлах ба нийлүүлэгчийн хагас бэлэн болсон бараа, гэрээг хэрэгжүүлэх зорилгоор худалдаж авсан материал, эд ангийн хэлэлцэж тохирсон үнийг төлнө. Энэ дунд захиргааны зардлын болон ашгийн зохих хэмжээг оруулж тооцно.
21. Маргааныг шийдвэрлэх	21.1.	Захиалагч болон нийлүүлэгчийн хооронд гэрээтэй холбогдож гарч болох маргааныг зөвшилцөл болон албан бус хэлэлцээрээр шийдвэхийг хичээнэ.
	21.2.	Дээрх хэлэлцээр 30 хоног үргэлжлэхэд гэрээний маргааныг талууд шийдвэж чадахгүй бол аль ч тал ГТН-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй.
22. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал	22.1.	Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнээс захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол ГЕН-ийн 16 дугаар зүйлийн дагуу түүнийг гүйцэтгэх хугацааг сунгана.
	22.2.	Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр

<sup>7</sup>Захиалагч гэрээг цуцлах шийдвэрийг холбогдох дээд шатны байгууллагын зөвшөөрөлтэйгээр зөвхөн зайлшгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд гаргана.

мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол нийлүүлэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.

- |                                       |  |
|---------------------------------------|--|
| <b>23. Гэрээний үүргийг шилжүүлэх</b> | 23.1. Ямарч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.   |
| <b>24. Гэрээнд ашиглах хэл</b>        | 24.1. Нийлүүлэгч ГТН-д заасан гэрээнд ашиглах хэлийг бүрэн ойлгох мэдлэгтэй гэдгээ үүгээр баталж байна. Гэрээ түүнд холбогдох баримт бичиг, харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.<br>24.2. 24.1-д заасан хэл рүү орчуулах зардал болон орчуулгын үнэн зөвийг нийлүүлэгч хариуцна. |
| <b>25. Татвар болон хураамж</b>       | 25.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оногдуулдаг бүх төрлийн татвар, хураамжийг нийлүүлэгч бүрэн хариуцна.  |
| <b>26. Гарчиг</b>                     | 26.1. Гэрээний бүлэг, зүйл болон бусад хэсгийн гарчиг нь зөвхөн тайлбарын шинжтэй бөгөөд гэрээний хэсэг болохгүй.  |
| <b>27. Үүргийн гүйцэтгэл</b>          | 27.1. Аль нэг тал нь гэрээний үүргээ гүйцэтгэхийг хатуу шаардаагүй нь нөгөө талын уг үүргийг биелүүлэхгүй байх шалтгаан болохгүй.  |
-

## ДОЛООДУГААР БҮЛЭГ

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<b>1. Тодорхойлолт (ГЕН - 1)</b>	1.1.(д)	Захиалагч нь <i>Эрдэнэс-Таван Толгой ХК</i>
<b>2. Шалгалт туршилт (ГЕН - 7)</b>	7.0	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг шалгах зорилгоор Захиалагчийн төлөөлөгч бараа, материалыг шалган туршиж хүлээн авах ба шаардлага хангаагүй доголдолтой бараа материалыг засварлуулах, солиулахыг шаардах эрхтэй ба нийлүүлэгч нь өөрийн хөрөнгөөр засварлах солих үүрэгтэй.
<b>3. Баглаа боодол (ГЕН - 8)</b>	8.0	Стандартын шаардлага хангасан зориулалтын сав баглаа боодолтой байна.
<b>4. Барааг хүргэх болон бичиг баримтын бүрдүүлэлт (ГЕН - 9)</b>	9.0 9.3	Нийлүүлэгч нь биет байдлын болон эрхийн зөрчил, доголдолгүй бараа материалыг Захиалагчийн заасан тоо, хэмжээ, чанарын дагуу Захиалагчийн Улаанбаатар төв оффисд хүргэж хүлээлгэн өгөх ба шаардлагатай бичиг баримтыг дагалдуулна.  1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь; 2) даатгалын гэрчилгээ; 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ; 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалт туршилтын гэрчилгээ;
<b>5. Даатгал (ГЕН - 12)</b>	12.0	Даатгалын тусгай шаардлага  Бараа материалыг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх төрлийн эрсдлийн даатгалын эрсдлийг Нийлүүлэгч тал өөрийн зардлаар бүрэн хариуцна.
<b>6. Баталгаат засвар (ГЕН-13)</b>	13.0	Баталгаат засварын тусгай шаардлага  Бараа материалын техникийн тодорхойлолтод заасан хугацаанд баталгаат засвартай байх ба уг хугацаанд Захиалагчийн буруутай үйлдэл, давагдашгүй хүчин зүйлс зэргээс гарсан гэмтлээс бусад аливаа доголдол илэрсэн тохиолдолд Нийлүүлэгч өөрийн хөрөнгөөр засварлах буюу шинэ ижил төрлийн бараа материалаар сольж өгнө. Баталгаат засварын хугацаанд гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах үүднээс гэрээний үнийн дунгийн 5%-ийг барьцаа болгон баталгаат хугацаанд авч үлдэнэ.

7. Төлбөр (ГЕН - 14) ГЕН-ийн 14 дүгээр зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<sup>8</sup>

14.4 Захиалагч гэрээ байгуулагдсанаас хойш хуваарийн дагуу нийлүүлэгдсэн хэрэглээнд үндэслэсэн гүйцэтгэлийг гарган захиалагч болон нийлүүлэгчийн хооронд үйлдсэн бараа хүлээлцэх акт, нэхэмжлэх болон холбогдох бичиг баримтыг үндэслэн Нийлүүлэгчийн тухайн сард нийлүүлсэн бараа материалын төлбөрийг нэхэмжлэх хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногт нийлүүлэгч байгууллагын дансанд бэлэн бусаар шилжүүлнэ.

Захиалагчийн тухайн бараа материалыг захиалан авах тоо ширхэг нь компанийн хэрэгцээ шаардлагад үндэслэн техникийн тодорхойлолтонд заасан тоо ширхэгээс бага байх тохиолдолд Захиалагч зөвхөн тухайн нийлүүлсэн бараа материалын үнийг Нийлүүлэгч талд төлнө.

Захиалагч техникийн тодорхойлолтонд заасан дээд хэмжээгээр бараа материалыг хүлээн авах үүрэг хүлээхгүй.

8. Маргааныг шийдвэрлэх (ГЕН - 21) 21.0 Нийлүүлэгч Монгол Улсын хуулийн этгээд бол талуудын хооронд гарсан маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.  
Нийлүүлэгч Монгол Улсын хуулийн этгээд биш тохиолдолд “Олон улсын худалдааны танхимины Арбитраж болон эвлэрийн дурмийн дагуу сонгогдсон арбитрын шүүгч энэ дурмийн дагуу маргааныг шийдвэрлэнэ”. Арбитрын байгууллага маргаан шийдвэрлэх ажиллагаа явагдах улсыг заах ба арбитрын байгууллагын шийдвэр эцсийнх бөгөөд талууд заавал биелүүлэх үүрэгтэй.

12. Давагдашгүй хүчин зүйл (ГЕН - 22)

Гэрээний ерөнхий нөхцлийн 22.1-д заасан давагдашгүй хүчин зүйлд төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр буюу УИХ, ЗГ, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг болон бусад төрийн байгууллагын шийдвэр хамаарах бөгөөд үүний улмаас талууд гэрээний үүргээ цаашид биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд талууд гэрээнд заасан үүрэг хариуцлагаас чөлөөлөгднө.

**НАЙМДУГААР БҮЛЭГ**

**ГЭРЭЭНИЙ МАЯГТ**

**БАТЛАВ.**

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

*[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.*

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас *[захиалагчийн нэр]* (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас *[нийлүүлэгчийн нэр]* (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож ..... оны ..... сарын ..... -ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь *[гэрээний нэр, дугаар]-г* (цаашид “бараа” гэх) *[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]* (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг .....төгрөгийн төвлөрсөн төсвийн хөрөнгөөр, ..... төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ..... төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь ..... нэр төрлийн барааг ..... оны ..... дугаар сарын ..... -нээс .....оны ..... дугаар сарын ..... -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх).  
Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>9</sup>;  
Тендер ба үнийн хуваарь;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Гэрээний тусгай нөхцөл;

<sup>9</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дунг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

## ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТЛАН ДААЛТ)

*[Захиалагч байгууллагын нэр]*

**[Гүйцэтгэгчийн нэр]** нь (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь **[Гэрээний нэр ба ажлын товч тодорхойлолт]** (цаашид “гэрээ” гэх) ажлыг гүйцэтгэх болсонтой ХОЛБОГДУУЛАН,

Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож захиалагчийн хүлээн зөвшөөрөх банкны гаргасан дор дурдсан дүнтэй батлан даалтыг захиалагчид ирүүлэхийг дээрх гэрээнд заасантай ХОЛБОГДУУЛАН,

**[Банкны нэр]** (цаашид “Банк” гэх) нь дараах батлан даалтыг гаргаж байна:

Банк нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс **[баталгааны дүн тоогоор, төгрөг]/[дүн үсгээр, төгрөг]<sup>10</sup>** –ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж байна. Ингэхдээ дээр дурдсан **[баталгааны дүн тоогоор, төгрөг]/[дүн үсгээр, төгрөг]**-ийн хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дунг ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, эсхүл түүний дагуу гүйцэтгэх ажил, эсхүл гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш /огноог оруулах/ хугацаанд хүчинтэйбайна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга

Огио:

Хаяг:

<sup>10</sup> Энэ дунг баталгаа гаргагч бөглөх бөгөөд гэрээнд заасан гэрээний үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь гэрээний валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.

## УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТЛАН ДААЛТ)

*[Захиалагч байгууллагын нэр]*

*[Гүйцэтгэгчийн нэр]* (цаашид “гүйцэтгэгч” гэх) ..... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... тоот *[Гэрээний нэр ба ажлын товч тодорхойлолт]* гэрээ (цаашид “гэрээ” гэх)-ний ерөнхий нөхцөлийн 48 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүргээ амжилттай биелүүлэхээ баталж *[Захиалагчийн нэр]*<sup>11</sup>-ийн өмнө хариуцлага хүлээж *[Баталгааны мөнгөн дүн]/[үсгээр]*<sup>12</sup>-ийн банкны баталгаа ирүүлэхтэй ХОЛБОГДУУЛАН,

*[Банк нэр]* (цаашид “Банк” гэх) нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс *[баталгааны дүн тоогоор, валюты]/[дүн үсгээр, валюты]*<sup>12</sup>-ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг захиалагчийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж батлан даалт гаргаж байна.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, түүний дагуу гүйцэтгэх ажил, гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэхүү баталгаа нь гэрээний нөхцөлийн дагуу захиалагчид дээр дурдсан дүнтэй ижил төлбөр эргэн төлөгдөх өдөр /огноог оруулах/ хүртэлхүчин төгөлдөр байна.

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

<sup>11</sup> Энэ дүнг банк, эсхүл санхүүгийн байгууллага бөглөх бөгөөд урьдчилгаа төлбөрийн үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь урьдчилгаа төлбөрийн валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.

<sup>12</sup> Энэ дүнг баталгаа гаргагч бөглөх бөгөөд гэрээнд заасан гэрээний үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь гэрээний валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.